



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий
боловсролын сургууль 2018 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/106/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг)
2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас:7052-2734 Цахим хаяг:
dornogovi@audit.dov.mn
Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
Утас:7035-2030 Цахим хаяг:
Аудитор: М.Мөнхнаран
Утас:99352464 Цахим хаяг:
mnbaudithhk@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	6
2.1	Оршил	6
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	7
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	8
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал Эд хариуцагч нартай хийсэн тооцоо бодсон акт, нормчлогдсон зардлын зарцуулалт 11	11
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	12
2.11	Шилэн дансны мэдээлэл	12
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	13
3.1	Балансын данстай холбоотой асуудал	14
3.2	Балансын данстай холбоотой асуудал	15

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
4102 Дорноговь аймгийн Сэлэнгэ сум,
Олон улсын аймагны III хороо,
Улаанбаатар 15110
2019.02.25 № 4-6/1918

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЭРДЭНЭ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ М.ГАНЦЭЦЭГ**

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Эрдэнэ сумын ЕБС-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт


Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үндэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

502000.



4. Боловсролын салбарын ажилтны цалин хөлсийг 2018 онд нэмэгдүүлэх асуудлаар хийсэн хэлэлцээрийн хүрээнд цалин хөлсний зөрүүг шийдвэрлэх зорилгоор БСШУСЯамны багцаас Төрийн үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох шийдвэрийг зөрчин төсвийн шууд захирагч 133.2 мянган төгрөгийн нэмэгдэл авсан байна.

Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнаж үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал М.Ганцэцэг-т танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.23-наас 2019.02.02-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын гэрээгээр “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.01.23-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль нь Аймагт үлгэр жишээ болохуйц сургалтын болон сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлсэн, сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлж уламжлал шинэчлэлийг хослуулсан эвсэг бүтээлч тэргүүний хамт олон болно гэсэн зорилго дэвшүүлэн ажиллаж байна. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа
- Боловсролын нэг буюу хэд хэдэн төвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- УСНББОУС стандарт

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг

хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 1 хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төлөвлөлтийн шатанд зардлыг суурь үзүүлэлт болгон сонгосон -холбоотой юм.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны *Нийт зардал* 556.424.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 5,564.24 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 0 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	158.40	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	7,939.50	
3	Албан шаардлага өгсөн	2	68,459.10	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	6	76,557.00	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

1. Тайлант хугацаанд тавилга, урсгал зардал, хичээл үйлдвэрлэл зардлаар батлагдсан нийт 42990.5 мянган төгрөгийн 3 төрлийн санхүүжилтээс шууд худалдан авалт хийсэн нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ, 8.4.Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно, Төсвийн тухай хуулийн 24.4. "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Сангийн сайдын 2013 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан Цахим тендер зохион байгуулах журам, Засгийн газрын Босго үнэ шинэчлэн батлах тухай 2013 оны 68 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 24 тогтоолоор батлагдсан журмын 9.1.1 " төсвийн жилийн эхэнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон батлагдсан төсвийг хэрхэн зүй зохистой удирдаж авлага, өр төлбөр шинээр үүсгэхгүй байх талаар төлөвлөгөө гаргаж мөрдүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Албан шаардлага өгч биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 25 дотор Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг санал болголоо.

2.8.1.2. Балансын данстай холбоотой асуудал

1. СИЗУ” ХХКомпанитай засварын ажил гүйцэтгэх гэрээг 2019 оны 11 сард байгуулан ажилласан бөгөөд гэрээнд заасны дагуу 2018 оны 12 дугаар сарын 06-нд урьдчилгаа төлбөр болох 13000.0 мянган төгрөгийг шилжүүлэн үлдэгдэл төлбөр болох 12468.6 мянган төгрөгийг ажил хүлээлцэж акт үйлдээгүй үед нэхэмжлэхэд үндэслэн олгож нийт 25468.6 мянган төгрөгийн авлага үүсгэсэн бөгөөд 2019 оны 1-р сард ажил дуусаагүй учир хүлээн аваагүй байна
2. Мөн Нийгмийн даатгалын байгууллага, Татварын хэлтэс, Байгаль хамгаалах сангийн дансруу нийт 7806.03 мянган төгрөг шилжүүлэн авлага үүсгэсэн байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" , 39.4.2 "өр, авлага үүсгэхгүй байх" , 45.2.Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ, 45.2.1.нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол", Төрийн сангийн төлбөр тооцооны журмын 5.7 " төсвийн байгууллага нь төлбөрийн хүсэлтийг үндэслэх баримтын хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтад амлалтын зөвшөөрөл, байгуулсан гэрээ хэлцэл, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын падаан эсвэл өр төлбөр байгааг нотолсон бусад бичиг баримт хамаарна" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Төсвийн байгууллагад шилжүүлэн авлага үүсгэсэн 7806.3 мянган төгрөгт төлбөрийн акт
2. “СИЗУ” ХХК-д шилжүүлэн авлага үүсгэсэн 25468.6 мянган төгрөгт албан шаардлага өгч биелэлтийг акт, албан шаардлагад тавигдсан хугацаанд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг санал болголоо.

2.8.1.3 Зардлын данстай холбоотой асуудал

Боловсролын салбарын ажилтны цалин хөлсийг 2018 онд нэмэгдүүлэх асуудлаар хийсэн хэлэлцээрийн хүрээнд цалин хөлсний зөрүүг шийдвэрлэх зорилгоор БСШУСЯамны багцаас Төрийн үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох шийдвэрийг зөрчин төсвийн шууд захирагч 133.2 мянган төгрөгийн нэмэгдэл авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 40.4.2 “хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Төлбөрийн акт тогтоож биелэлтийг 2019 оны 3 дугаар сарын 25-ны дотор Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэхийг санал болголоо.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Эд хариуцагчийн сар бүрийн материалын тооцоо бодсон акт, нормчлогдсон зардлын зарцуулах хувь хэмжээг тодорхойлон үйл ажиллагаандаа мөрдөж байгаа эсэх

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой (11) хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд (601,152,6) мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 599,389,1 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь тайлант хугацааны цалин хөлс болон нэмэгдэл урамшил, албан томилолт болон бусад зардал дээр хэмнэлт үүсгэсэн нь төсвийн хэмнэлтийг үүсгэсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт

Санхүүгийн байдлын тайлан дахь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн эхний үлдэгдэл нь шимтгэлийн тайлангийн эхний үлдэгдлээс зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь НББ-ийн тухай хууль 20.2.5 - 6 заалт болон Төсвийн тухай хуулийн 6.4.8 заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

1. Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх

Зөвлөмж

Тайлант хугацааны эцэс бүрт харилцагч байгууллагатай үлдэгдлийн тулган баталгаажуулалт хийж байх,

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн Нягтлан бодогч Э.Эрдэнэсүвд

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 19-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт

Төрийн болон орон нутгийн үндсэн хөрөнгийг холбогдох дээд байгууллагын шийдвэрийг харгалзахгүйгээр данснаас хассан байна.

Энэ нь Дорноговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 58-р тогтоолын хавсралт 2.1.1, 2.1.2,-р заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 70 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заалт тус тус зөрчсөн байна.

Эрсдэл

1. Цаашид ашиглах боломжтой, эсвэл хугацаа дуусаагүй үндсэн хөрөнгийг данснаас хасах нэрээр төсвийн хөрөнгийг ашиглах боломж үүсэх магадлалтай

Зөвлөмж

Хөрөнгийг актлахдаа эх үүсвэрийг тодруулж дээд байгууллагын шийдвэрт үндэслэх, данснаас хасах, устгахдаа нотлох баримт бүрдүүлэх

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн Нягтлан бодогч Э.Эрдэнэсүвд

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 19-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад (2019 оны 12 сарын 25-ны)-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Ч.АРИУНАА

Ц.ЛҮНДЭГМАА

М.МӨНХНАРАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>95,852,642.92</u>	<u>136,711,642.72</u>
33	АВЛАГА	1,246,200.00	33,274,916.00
335	Бусад авлага	1,246,200.00	33,274,916.00
3351	Байгууллагаас авах авлага	1,246,200.00	33,274,916.00
35	БАРАА МАТЕРИАЛ	94,606,442.92	103,436,726.72
351	Түүхий эд материал	20,702,210.00	28,318,564.90
35110	Тусгай зориулалттай материал	20,583,060.00	28,118,564.90
35130	Эм боох материал	119,150.00	200,000.00
354	Хангамжийн материал	71,769,232.92	72,798,161.82
35410	Бичиг хэргийн материал	4,650,886.00	4,832,726.00
35420	Аж ахуйн материал	8,901,855.00	11,012,705.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,360,000.00	3,360,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,331,490.00	1,140,480.00
35450	Барилгын засварын материал	00.00	7,767,000.00
35460	Хүнсний материал	2,945,096.00	2,336,720.00
35470	Бусад хангамжийн материал	51,579,905.92	42,348,530.82
35600	Мал амьтад	2,135,000.00	2,320,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>825,764,319.92</u>	<u>571,320,655.60</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	825,764,319.92	571,320,655.60
392	Биет хөрөнгө	825,543,486.75	553,868,655.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	838,524,544.00	394,529,492.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-124,366,164.59	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,600,000.00	20,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,586,111.07	-14,019,444.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	121,146,952.29	148,101,681.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	-65,940,816.77	-72,308,661.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,567,521.75	77,234,509.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,300,989.39	-24,790,032.93
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,522,995.36	11,522,995.36
39215	Хуримтлагдсан элэгдэл	-57,803.39	-1,984,542.43

Эрдэнэ сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39217	Ном	12,433,358.56	14,982,658.56
393	Биет бус хөрөнгө	220,833.17	17,452,000.00
39301	Програм хангамж	25,000.00	25,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-25,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	400,000.00	17,852,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-204,166.83	-400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>921,616,962.84</u>	<u>708,032,298.32</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>949,303.41</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	949,303.41	00.00
413	Өглөг	949,303.41	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>920,667,659.43</u>	<u>708,032,298.32</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	920,667,659.43	708,032,298.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	632,070,733.04	649,522,733.04
51101	Өмч: - төрийн	632,070,733.04	649,522,733.04
512	Хуримтлагдсан үр дүн	140,249,157.24	213,449,574.42
51210	Өмнөх үеийн үр дүн	140,249,157.24	140,249,157.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	73,200,417.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	148,347,769.15	-154,940,009.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>921,616,962.84</u>	<u>708,032,298.32</u>

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	225,492,985.92	629,624,241.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,078,709.92	20,837,261.10
120	Нийтлэг татварын бус орлого	1,078,709.92	20,837,261.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,078,709.92	19,866,661.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	251,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	857,529.92	260,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	221,180.00	19,355,161.10
120009	Бусад орлого	00.00	970,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,222,076.00	7,634,380.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	220,192,200.00	601,152,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,737,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,737,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,222,076.00	5,896,980.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,222,076.00	5,896,980.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	231,348,352.03	554,280,989.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	231,348,352.03	554,280,989.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	218,292,476.03	527,383,835.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,041,825.00	308,407,231.59
210101	Үндсэн цалин	113,738,246.00	264,389,181.59
210102	Нэмэгдэл	30,914,500.00	23,948,238.00
210104	Урамшуулал	8,597,053.00	17,699,812.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,792,026.00	2,370,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,689,554.00	36,234,048.00
210201	Тэтгэврийн даатгал	9,984,645.00	23,602,136.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,147,124.00	3,016,586.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,450,420.00	2,661,383.00
210204	Ажилгүйдлийн даатгал	255,929.00	670,843.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,851,436.00	6,283,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,948,981.00	102,833,986.00
210301	Гэрэл, цахилгаан	3,020,131.00	1,282,835.00
210302	Түлш, халаалт	6,041,955.00	100,399,360.00
210303	Цэвэр, бохир ус	886,895.00	1,151,791.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,562,492.70	11,106,052.00
210401	Бичиг хэрэг	1,487,025.00	2,999,540.00
210402	Тээвэр, шатахуун	642,500.00	2,469,470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	350,256.00	1,458,092.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,082,711.70	3,978,950.00
2105	Нормативт зардал	5,330,620.00	20,069,256.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,000.00	119,150.00
210502	Хоол, хүнс	5,284,620.00	19,950,106.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	270,000.00	1,706,259.00
210604	Урсгал засвар	270,000.00	1,706,259.00
2107	Томилолт, зочны зардал	180,000.00	1,391,700.00
210701	Гадаад албан томилолт	00.00	242,000.00
210702	Дотоод албан томилолт	180,000.00	1,149,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,174,540.00	2,623,370.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,174,540.00	2,623,370.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,094,463.33	43,011,933.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,537,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,454,450.00	306,200.00

Эрдэнэ сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,640,013.33	41,168,583.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,055,876.00	26,897,154.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	1,944,974.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	1,944,974.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,055,876.00	24,952,180.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,954,459.00	5,896,980.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	267,617.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,833,800.00	5,647,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	13,408,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-5,855,366.11</u>	<u>75,343,251.14</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,142,833.96
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	977,833.96
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	1,165,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-2,142,833.96
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-5,855,366.11</u>	<u>73,200,417.18</u>

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	225,637,976.00	610,269,080.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,223,700.00	1,482,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,223,700.00	1,482,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,223,700.00	511,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	251,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,223,700.00	260,000.00
120009	Бусад орлого	00.00	970,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	224,414,276.00	608,786,980.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	220,192,200.00	601,152,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,737,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,737,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,222,076.00	5,896,980.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,222,076.00	5,896,980.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	207,851,705.00	564,433,480.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	207,851,705.00	564,433,480.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	194,795,829.00	527,399,326.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,421,660.00	307,905,240.00
210101	Үндсэн цалин	111,059,007.00	221,186,240.00
210102	Нэмэгдэл	30,914,500.00	54,408,500.00
210104	Урамшуулал	8,597,053.00	24,410,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,851,100.00	7,900,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,336,393.00	42,646,800.00
210201	Тэтгэврийн даатгал	11,227,017.00	30,777,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	344,536.00	2,967,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,335,853.00	2,373,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	105,887.00	593,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,323,100.00	5,934,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,361,781.00	104,633,986.00
210301	Гэрэл, цахилгаан	3,020,131.00	1,087,776.00
210302	Түлш, халаалт	4,508,755.00	100,399,360.00
210303	Цэвэр, бохир ус	832,895.00	3,146,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,556,056.00	9,906,332.00
210401	Бичиг хэрэг	164,700.00	1,852,920.00
210402	Тээвэр, шатахуун	501,500.00	2,198,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	355,056.00	1,472,752.00
210404	Ном, хэвлэл	82,200.00	1,011,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	141,000.00	279,680.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	311,600.00	3,090,700.00
2105	Нормативт зардал	2,030,499.00	10,077,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,600.00	200,000.00
210502	Хоол, хүнс	2,003,899.00	9,201,530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	676,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250,000.00	39,822,818.00
210602	Тавилга	00.00	4,300,000.00
210604	Урсгал засвар	250,000.00	35,522,818.00
2107	Томилолт, зочны зардал	180,000.00	1,332,500.00
210702	Дотоод албан томилолт	180,000.00	1,332,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,478,440.00	2,468,170.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,478,440.00	2,468,170.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,181,000.00	8,605,950.00

Эрдэнэ сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,000.00	2,386,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,100,000.00	6,219,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,055,876.00	37,034,154.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	1,944,974.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	1,944,974.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,055,876.00	35,089,180.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,222,076.00	5,896,980.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,833,800.00	15,784,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	13,408,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,786,271.00	45,835,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	45,835,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	45,835,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	45,835,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	45,835,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-45,835,600.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,786,271.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,786,271.00	00.00

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	632,070,733.04	148,347,769.15	71,991,693.40	852,410,195.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	632,070,733.04	148,347,769.15	71,991,693.40	852,410,195.59
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,855,366.11	-5,855,366.11
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	632,070,733.04	148,347,769.15	140,249,157.24	920,667,659.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	632,070,733.04	148,347,769.15	140,249,157.24	920,667,659.43
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	- 303,287,778.29	00.00	- 303,287,778.29
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	17,452,000.00	00.00	73,200,417.18	90,652,417.18
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	649,522,733.04	- 154,940,009.14	213,449,574.42	708,032,298.32

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	601,152,600.00	607,049,580.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	601,152,600.00	607,049,580.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	571,745,000.00	570,196,966.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	309,039,500.00	307,905,240.00
210101	Үндсэн цалин	222,320,500.00	221,186,240.00
210102	Нэмэгдэл	54,408,500.00	54,408,500.00
210104	Урамшуулал	24,410,100.00	24,410,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,900,400.00	7,900,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,646,800.00	42,646,800.00
210201	Тэтгэврийн даатгал	30,777,100.00	30,777,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,967,400.00	2,967,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,373,900.00	2,373,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	593,500.00	593,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,934,900.00	5,934,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,645,800.00	104,633,986.00
210301	Гэрэл, цахилгаан	1,087,800.00	1,087,776.00
210302	Түлш, халаалт	100,400,000.00	100,399,360.00
210303	Цэвэр, бохир ус	3,158,000.00	3,146,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,390,700.00	12,305,632.00
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,799,720.00
210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	2,198,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,472,752.00
210404	Ном, хэвлэл	3,464,000.00	3,464,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	282,000.00	279,680.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,144,700.00	3,090,700.00
2105	Нормативт зардал	10,078,600.00	10,077,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	200,000.00
210502	Хоол, хүнс	9,202,600.00	9,201,530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	676,000.00	676,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	69,247,400.00	69,247,118.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00
210602	Тавилга	30,114,300.00	30,114,300.00
210604	Урсгал засвар	37,633,100.00	37,632,818.00
2107	Томилолт, зочны зардал	1,619,500.00	1,332,500.00
210702	Дотоод албан томилолт	1,619,500.00	1,332,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000.00	471,710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	471,710.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21576700.00	21576450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,264,800.00	2,264,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,311,900.00	19,311,900.00

Эрдэнэ сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29407600.00	36852614.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	1,763,434.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	1,763,434.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,407,600.00	35,089,180.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	5,896,980.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,999,600.00	15,784,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,408,000.00	13,408,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	601,152,600.00	607,049,580.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	601,152,600.00	601,152,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	601,152,600.00	601,152,600.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	5,896,980.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	5,896,980.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38.00	38.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00